

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**

**2021**



**ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,  
ГЭМТ ХЭРГИЙН ТАНИЛЦУУЛГА**

**ХЯНАСАН:**

Д.Мөнхзул

ЧД-ын Статистикийн хэлтсийн дарга

**ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:**

М.Батхишиг

ЧД-ын Статистикийн хэлтсийн  
ахлах мэргэжилтэн

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС  
МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ  
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, САМБУУГИЙН ГУДАМЖ  
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БАЙР  
401 тоот

Утас: 976- 70113013

976- 70110767

976- 70130767

976-11-310767

Цахим хуудас: [www.ubstat.mn](http://www.ubstat.mn)[www.chingeltei.gov.mn](http://www.chingeltei.gov.mn)Фэйсбүүк хаяг: [chingelteistatistic](https://www.facebook.com/chingelteistatistic)И-мэйл: [chingeltei@nso.mn](mailto:chingeltei@nso.mn)



## ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Дүүргийн Онцгой байдлын хэлтэс нь 2021 онд Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр дээр гарсан 364 гал түймрийн дуудлага хүлээн авсан нь өмнөх оноос 100 (21.6%)-аар буурсан байна. Зарцуулсан хөрөнгө өмнөх оноос 1.8 дахин, хамгаалсан хөрөнгө 1.8 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Гал түймрийн дуудлага, зарцуулсан хөрөнгийн үзүүлэлт, оноор

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2017	2018	2019	2020	2020	<u>2020</u> 2019
Дуудлагын тоо	Тоо	670	863	690	464	364	-21.6%
Гал түймэр	Тоо	471	651	527	368	296	-19.6%
Иргэд унтраасан гал түймэр	Тоо	169	175	145	85	52	-38.8%
Өөрөө унтарсан гал түймэр	Тоо	20	25	12	8	11	-1.4%
Худал дуудлага	Тоо	10	12	11	15	15	-66.7%
Ашиглагдсан ус	Тонн	743.8	879.5	881.3	642.3	158.8	-87.7%
Ашиглагдсан шатахуун	Литр	26 531.1	26 751.1	12 553.1	9 069.9	4 687.2	-24.1%
Зарцуулсан, мөнгө	Сая.төг	43.9	66.1	27.4	100.0	278	83.4%
Аварсан хүний тоо	Тоо	567	288	220	426	606	1.4%
Унтраасан барилга байшингийн тоо	Тоо	208	225	277	170	245	-1.4%
Нийт өмч хөрөнгө	Сая.төг	3 800	7 130	10 855.7	31 021.0	16 0701.0	46.2%



## ГЭМТ ХЭРЭГ


Бүртгэгдсэн гэмт хэрэг Монгол Улсын хэмжээнд 25429 болж өмнөх оноос 2365 (10.3%) хэргээр, Нийслэлийн хэмжээнд 16534 болж өмнөх оноос 1901 (13.0%) Чингэлтэй дүүрэгт 1864 болж өмнөх оноос 89 (5.0%) хэргээр тус тус өссөн байна.

Хүснэгт 2. Монгол Улс, нийслэл, дүүрэгт бүртгэгдсэн гэмт хэрэг, оноор

Захиргаа	2017	2018	2019	2020	2021	Өөрчлөлт	<u>2021</u> 2020
Улсын дүн	32 259	36 220	31 524	23 064	25 429	2 365	10.3%
Нийслэлийн дүн	21 947	25 652	20 261	14 633	16 534	1 901	13.0%
<b>Чингэлтэй</b>	<b>2 719</b>	<b>2 776</b>	<b>2 642</b>	<b>1 775</b>	<b>1 864</b>	<b>89</b>	<b>5.0%</b>
Багануур	254	253	167	143	163	20	14.0%
Багахангай	31	24	14	26	20	-6	-23.1%
Баянгол	3 204	4 501	2 834	2 257	2 758	501	22.2%
Баянзүрх	5 939	7 522	5 465	4 083	4 217	134	3.3%
Налайх	393	420	331	339	279	-60	-17.7%
Сонгинохайрхан	3 691	3 692	3 470	2 337	2 903	566	24.2%
Сүхбаатар	3 816	4 132	3 283	2 023	2 285	262	13.0%
Хан-Уул	1 900	2 332	2 055	1 650	2 045	395	23.9%

Нийслэлийн хэмжээнд гэмт хэргийн гаралт 13.0 хувиар өсөхөд Сүхбаатар дүүрэг 13.0 хувиар, Чингэлтэй дүүрэг 5.0 хувиар, Сонгинохайрхан дүүрэг 24.2 хувиар, Баянзүрх дүүрэг 3.3 хувиар, Баянгол дүүрэг 22.2 хувиар, Хан-Уул дүүрэг 23.9 хувиар, Багануур дүүрэг 14.0 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 1. Чингэлтэй дүүргийн гэмт хэрэг, улс, нийслэлийн дүнд эзлэх хувиар




Монгол Улсын нийт гэмт хэргийн дүнд Чингэлтэй дүүргийн эзлэх жин 2012 онд 8.2 хувь байсан бол 2021 онд 7.3 хувь болж 0.4 пунктээр, нийслэл хотын дүнд эзлэх хувь 12.1 хувь байсан бол 11.3 хувь болж 0.8 пунктээр буурсан байна. /Энэхүү бууралт нь гэмт хэргийн гаралтанд нөлөөлөх хүчин зүйлс буурч, урьдчилан сэргийлэх ажлыг

эрчимжүүлсэн Цагдаагийн бие бүрэлдэхүүний хүчин чармайлтыг илтгэж байна./

Дүүргийн гэмт хэргийн өсөлтийн хувь 2021 онд улсын дүнгээс 5.1 пунктээр, нийслэлийн дүнгээс 7.9 пунктээр бага байна.

Зураг 2. Гэмт хэргийн өсөлт, оноор



Зургаас харахад 2013 оноос гэмт хэргийн гаралт буурч байсан боловч 2017 онд өсч, 2018 оноос эргэн буурсан байна (Зураг2). Өмнөх онтой харьцуулахад 2021 онд улс, нийслэл, дүүргийн цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэг өссөн хандлагатай байна.

Дүүргийн Цагдаагийн I хэлтэс нь 1-9 дүгээр хороог хариуцан ажилладаг, Цагдаагийн II хэлтэс нь 10-19 дүгээр хорооны нутаг дэвсгэрийг хариуцан ажилладаг болно. Хүснэгтэд гэмт хэргийг төрлөөр нь ангилан, Цагдаагийн I, II хэлтэст бүртгэгдсэн дүнгээр үзүүлэв.

Хүснэгт 3. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хэргийн ангиллаар, оноор

Гэмт хэргийн төрөл	2020			2021		
	Нийт дүн	Цагдаагийн I хэлтэс	Цагдаагийн II хэлтэс	Нийт дүн	Цагдаагийн I хэлтэс	Цагдаагийн II хэлтэс
Нийт гэмт хэрэг	1 775	1 103	672	1864	875	989
Хүний амьд явахыг эсрэг	17	6	11	24	6	18
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	565	250	315	496	217	279
Гэр бүлийн хүчирхийлэл	6	4	2	2	2	0
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	30	6	24	20	12	8
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг	36	32	4	15	11	4
Эрүүл мэндийн эсрэг	1	1	0	2	2	0
Хүүхдийн эсрэг	3	2	1	1	1	0
Өмчлөх эрхийн эсрэг	994	720	274	1 119	523	596
Эдийн засгийн	13	12	1	23	15	8
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	33	23	10	83	42	41
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	5	5	0	3	3	0
Авилгын эсрэг	0	0	0	0	0	0
нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	19	15	4	17	13	4
Хүрээлэн байгаа орчны эсрэг	11	8	3	6	3	3
Соёлын өвийн эсрэг	1	1	0	2	2	0
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	11	8	3	6	2	4
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	36	14	22	47	23	24

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлийн 2.6-д заасны дагуу гэмт хэргийг ангиллаар нь хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилдаг байсан бол 2017 оны 5 сарын 11-ний өдөр батлагдсан шинэчилсэн найруулгаар гэмт хэргийн ангиллыг ХӨНГӨН, ХҮНД гэсэн 2 ангилалтай байхаар өөрчилсөн байна.

Хүснэгт 4. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хэргийн ангиллаар, оноор

Гэмт хэргийн төрөл		2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Нийт гэмт хэрэг		2 115	2 393	2 254	2 337	2 719	2 776	2 642	1775	1864
Гэмт хэргийн ангилалаар	Хөнгөн	1 018	1 168	1 050	1 103	1 503	2 043	2 053	1486	1682
	Хүндэвтэр	868	1 001	1 011	1 078	537	-	-	-	-
	Хүнд	177	172	142	107	653	733	589	289	182
	Онц хүнд	52	52	51	49	26	-	-	-	-

Зураг 3. Бүртгэгдсэн гэмт хэргийн тархалт, ангилалаар, оноор



Дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн 2021 оны гэмт хэргийн 90.2 хувийг хөнгөн гэмт хэрэг, 9.8 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж байна. Энэ нь үйлдэгдэж буй 5 хэрэг тутмын 1 нь хүнд гэмт хэрэг байгааг харуулж байна.

## Хүснэгт 5. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хэргийн төрлөөр, оноор

Гэмт хэргийн төрөл	2014	2015	2016	2017	2018	2019	2021	Өөрчлөлт	<u>2021</u> 2020
Нийт гэмт хэрэг	2 254	2 337	2 719	2 776	2642	1775	1864	89	5.0
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	547	563	628	660	578	580	519	-61	-10.5
<i>Хүнийг санаатай алах</i>	13	14	17	19	21	7	16	9	1.3
<i>Бусдын бие махбодид гэмтэл учруулах</i>	524	544	586	625	541	565	496	-69	-12.2
<i>Бусдыг амиа хорлоход хүргэх</i>	10	5	25	16	16	8	7	-1	-12.5
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	1 068	1 276	1 659	1 716	1765	994	1 119	125	12.6
<i>Хулгай</i>	722	908	1 167	1 013	888	426	304	-122	-28.6
<i>Булаалт</i>	14	24	2	-	-	-	-	-	-
<i>Дээрэм</i>	41	54	113	87	71	32	19	-13	-40.6
<i>Залилан</i>	291	290	377	616	558	435	700	265	60.9
<i>Бусад</i>	-	-	-	-	241	101	96	-5	-5.0
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	159	125	80	64	32	20	17	-3	-15.0
<i>Хүчиндэх</i>	13	17	24	21	32	20	17	-3	-15.0
<i>Танхайрах</i>	146	108	56	43	-	-	-	-	-
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	142	108	62	51	50	36	47	11	30.6
Бусад гэмт хэрэг	338	265	290	285	224	145	162	17	11.7

Гэмт хэргийн төрлөөр нарийвчлан авч үзвэл залилан мэхлэх гэмт хэрэг 60.9 хувиар өссөн байна. 2021 онд нийт гэмт хэрэг 5.0 хувиар өссөн байна. Үүнд хүнийг санаатай алах хэрэг 1.3 хувиар, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 12.6 хувиар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 30.6 хувиар, бусад гэмт хэрэг 11.7 хувиар тус тус өссөн байна.

Гэмт хэрэг үйлдэгсэд 2021 онд 1222 болж өмнөх оноос 190 (18.4%) хүнээр өссөн байна. Гэмт хэрэг үйлдсэдийн 261 буюу 21.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа ба уг үзүүлэлт өмнөх оноос 9.5 пунктээр өссөн байна.


#### Хүснэгт 7. Гэмт хэрэг үйлдэгсэд, насны ангиллаар, оноор

Насны ангилал	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Нийт гэмт хэрэг үйлдэгч	1 756	1 832	1 682	1 875	1 430	1 137	1 187	1032	1222
15 хүртэл	30	29	18	26	34	42	30	22	11
16-17 нас	81	79	52	74	68	48	57	36	33
18-24 нас	521	484	454	457	359	268	303	216	419
25-29 нас	359	400	394	384	310	215	222	196	206
30-34 нас	236	260	265	318	219	213	178	177	229
35-39 нас	185	209	174	212	132	123	134	120	116
40-44 нас	150	151	129	169	108	101	97	91	75
45-49 нас	97	104	76	108	83	55	66	78	66
50-54 нас	67	69	66	84	57	32	57	43	39
55-59 нас	21	27	33	29	40	26	29	26	14
60-64 нас	7	9	14	4	14	7	12	24	13
65-69 нас	-	7	5	7	2	2	2	3	1
70, түүнээс дээш	2	4	2	3	4	5	-	-	-


Дүүргийн нийт хүн амын 0.8 хувь, эмэгтэйчүүдийн 0.3 хувь нь гэмт хэрэг үйлдсэн байна. Гэмт хэрэг үйлдсэн иргэдийн ихэнх буюу 34.2 хувь нь 18-29 насны залуус байна.

Улсын хэмжээнд 2019 онд нийт 543 сурагч гэмт хэрэг үйлдсэн нь өмнөх оноос 6 (1.1%)-аар буурсан байна. Чингэлтэй дүүргийн 26 сурагч гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогджээ. Гэмт хэрэг үйлдсэн хүний тоо өмнөх оноос 21.4 хувиар өсч, гэмт хэрэг үйлдсэн сурагчийн тоо буурсан байна. Гэмт хэрэгт холбогдохгүй байх, болзошгүй эрсдэлээс сэргийлсэн сургалт, мэдээллийг түгээхэд түлхүү анхаарах шаардлагатай байна.

Зураг 4. Гэмт хэрэг үйлдэгсэд насны бүлгээр, хувиар, 2020 он



Зураг 5. Гэмт хэрэг үйлдэгсэд боловсролын түвшинээр, хувиар, 2020 он





Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо 2021 онд 1782 болж өмнөх оноос 22 (1.3%) хүнээр өссөн байна. Хохирсон иргэдийн 50.4 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оноос 4.9 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

**Хүснэгт 8. Гэмт хэргийн улмаар хохирсон иргэдийн тоо, насны бүлгээр, оноор**


Насны ангилал	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Нийт	2 101	2 241	1 966	2 363	2 574	2 633	2 503	1 760	1 782
7 хүртэл	-	-	-	-	11	6	15	5	4
8-13 нас	58	32	41	43	49	38	35	16	23
14-17 нас	68	87	52	57	92	80	60	59	47
18-24 нас	430	405	301	339	349	336	374	228	285
25-29 нас	383	452	374	444	471	465	334	250	263
30-34 нас	303	363	309	340	424	438	437	331	356
35-39 нас	270	270	237	328	310	347	333	233	233
40-44 нас	179	216	195	276	266	283	269	187	190
45-49 нас	166	156	164	195	213	225	225	153	151
50-54 нас	121	109	148	170	166	181	182	122	101
55-59 нас	61	88	77	92	110	117	128	90	66
60-64 нас	30	32	27	34	60	60	61	50	39
65-69 нас	10	18	21	24	28	35	19	19	16
70, түүнээс дээш	22	13	20	21	25	22	31	17	8

Дүүргийн нийт хүн амын 1.2 хувь, эмэгтэйчүүдийн 1.2 хувь нь гэмт хэргийн хохирогч болсон байна. Нийт хохирогчдын 40.6 хувийг тухайн үед нь хамгаалалтад авч ажилласан байна. Мөн 4 иргэн өөрийн буруутай үйл ажиллагаанаас болж хохирогч болсон бол 1 хүн архидагч согтуурч байх үедээ хохирсон байна. Энэ нь өмнөх оноос 3 (42.9%)-аар буурсан байна.


Зураг 6. Гэмт хэргийн хохирогч хөдөлмөр эрхлэлтийн байдлаар, хувиар, 2020 он



Зураг 7. Гэмт хэргийн хохирогч насны бүлгээр, хувиар, 2020 он




Зураг 8. Гэмт хэргийн хохирогчдын тоо, ураг төрлийн хамаарлаар оноор



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон иргэд 86 болж өмнөх оноос 13 (1.8 дахин) хүнээр өссөн байна. Гэр бүлийн хүчирхийллийн гол хохирогч хамтран амьдрагч байх тохиолдол 2021 онд 31 бүртгэгдэж өмнөх оноос 5 (1.6 дахин)-аар, хохирогч эхнэр байх тохиолдол 29 бүртгэгдэж өмнөх оноос 7 (0.2 дахин) хүнээр өссөн байна.

Зураг 9. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар, хувиар



**Зам тээврийн осол, зөрчил:** Дүүргийн Замын цагдаагийн тасгийн бүрэлдэхүүний гудамж, замд хийсэн хяналт шалгалтаар 2021 онд 46514 зөрчил илрүүлснээс нийт 43604 жолоочийг 1.5 тэрбум төгрөгөөр торгож ажилласан байна.

Өмнөх оноос илрүүлсэн зөрчил 66857 (59.0%), торгуулсан жолооч 66892 (60.5%), торгуулсан мөнгөний хэмжээ 967.0 (38.7%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Хүснэгт 9. Торгуулсан жолоочийн тоо, торгуулийн хэмжээ

Торгууль	2018 I-XII	2019 I-XII	2020 I-XII	2021 I-XII
Торгуулсан жолоочийн тоо	108296	137 469	110 496	43 604
Торгуулийн нийт хэмжээ /сая төгрөг/	2889	3 188	2 501	1 534
Торгуулийн дундаж хэмжээ /төгрөг/	26676	23 190	22 634	35 180

Хүснэгт 10. Зам тээврийн зөрчил, зөрчлийн хэлбэрээр

Зөрчлийн хэлбэр					
	2017	2018	2019	2020	2021
НИЙТ ЗӨРЧИЛ	107107	123655	141085	113371	46514
Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон	2473	2 570	2 570	2 581	2 318
Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, боловч тээврийн хэрэгсэл жолоодсон	318	329	329	582	473
Бүрэн бүс тээврийн хэрэгсэл жолоодсон	7158	8 570	8 570	8 411	1 127
Хамгаалах бүс хэрэглээгүй	10 904	9 393	9 393	4 627	334
Хориглосон нөхцөлөөр зогссон	29 117	32 247	32 247	60 720	1 976
Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн	3 020	4 349	4 349	692	28
Эгнээ байраа буруу эзэлсэн	10 021	10 112	10 112	6 452	609
Бусад зөрчил	44 096	56 085	56 085	57 020	35 723

2021 онд цагдаагийн нийтлэг үүргийн дагуу нийт 37, АСАП санд эрэн сурвалжлагдаж байсан нийт 56 иргэнийг илрүүлж харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн ажилласан.



# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



## ГЭМТ ХЭРЭГ

### БҮХ ГЭМТ ХЭРЭГ



### ГЭМТ ХЭРГИЙН ТӨРӨЛ



Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 279 болж өмнөх оноос 6.9% нэмэгдсэн байна.



Хулгай, залилангийн хэрэг нийт гэмт хэргийн **53.9%** эзлэж байна.

### Хохирогч:

НИЙТ	1 782	1.52%
ЭМЭГТЭЙ	899	12.1%
Хүүхэд	74	7.5%

Гэмт хэргийн 41% орон гэрт үйлдэгдсэн

Гэмт хэргийн 22% гудамж талбай

Гэмт хэргийн 9% олон нийтийн газар

Гэмт хэргийн 12% бусад газар үйлдэгдсэн

